

## 2

## САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛИЙН ТОЙМ, ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

### Б.Сайнжаргал

Үндэсний нягтлан бодох бүртгэл, тайлагнал, аудитын тогтолцоог төлөвшүүлэх асуудлыг авч үзэхдээ зөвхөн гүйцэтгэлийг тайлагнах, түүний үр дүнг хянах утгаар бус тухайн мэдээллийг удирдлагын болон хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргахад, нэн шаардлагатай бодит мэдээлэл өгөх, өөрөөр хэлбэл бүртгэл тайлагналд хэрэглээний байр сууринаас хандах нь чухал болж байна.

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн хуулинд “Нягтлан бодох бүртгэлийн маягт аргачлал нь улсын эдийн засгийн үндсэн салбаруудыг хөгжүүлэх, өмч эзэмшигчээс үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх, удирдлагын шийдвэр гаргах, хяналт тавих бололцоотой байх ...” гэж заасныг удирдлага болгон санхүүгийн тайлангийн үнэн зөв, мэдээллийн хүрэлцэхүйц байдлыг хангах, тэдгээр мэдээлэлд судалгаа хийж, үнэлгээ дүгнэлт өгөх санхүүгийн шинжилгээний арга зүй зохион байгуулалтыг боловсронгуй болгох, бизнесийн салбар, үйл ажиллагааны онцлогт нийцсэн шинжилгээний үзүүлэлтийн системийг боловсруулж мөрдөх шаардлагатай болсон юм.

**1. Шинжилгээний арга зүй, зохион байгуулалтын шинэчлэлт**

Шинжилгээний арга зүй зохион байгуулалтын шинэчлэлтийг хэрэгжүүлэхдээ Зах зээлийн орнуудад түгээмэл хэрэглэгддэг үзүүлэлт, тэдгээрийг тооцоолдог арга зүйг удирдлага болгохын хамт, өөрийн орны өвөрмөц онцлог, нөхцөл байдалд нийцсэн, бас түүхэн уламжлал төдийгүй санхүүгийн шинжилгээний хөгжлийн өнөөгийн болон ирээдүйн чиг хандлагыг тусгасан байх шаардлагыг чухалчилж байгаа юм. Энэ үүднээс орчин үеийн мэдээллийн системд шинжилгээний эзлэх байр суурийг бусад шинжлэх ухаантай холбон тодорхойлох, шинээр нэвтрүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн хэв загварт тохирсон шинжилгээний үзүүлэлтийн системийг тогтоох, манай бизнесийн нэгжүүдийн эрхэлж буй үйл ажиллагаа, хөрөнгө чинээ, санхүүжилтийн өнөөгийн онцлогоос хамаарч үндсэн үзүүлэлтүүд /санхүүгийн харьцаанууд/-ын стандарт хэмжээ ямар байгааг цаг хугацааны болон орон зайн /салбар, бүс нутаг гм/ зэрэгцүүлэлтээр тодорхойлоход чиглэсэн нэг сэдэвт хэд хэдэн судалгааны ажлууд хийгдэж, зарим бүтээлээр боловсролын болон эрдмийн зэрэг хамгааллаа<sup>1</sup>.


Эдгээр судалгааны ажлын үр дүнд бизнесийн байгууллагын санхүү-эдийн засгийн шинжилгээний зохион байгуулалтыг байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны онцлог, өмчийн хэлбэр, удирдлагын чиг үүрэгтэй нь уялдуулах, шинжилгээг тодорхой үе шат, эрэмбэ дарааллаар явуулах, судалгааны үр дүн, үнэлгээ дүгнэлтийг удирдлагын шийдвэр гаргалтанд хэрхэн ашиглах асуудлыг чухалчилах нь зүйтэй гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

Энэ байр сууринаас хандвал бизнесийн байгууллагын санхүүгийн шинжилгээний агуулга, эрэмбэ дарааллыг Бүдүүвч 1-ээр тодорхойлж болох юм.

<sup>1</sup> Б. Сайнжаргал “Санхүүгийн тайлангийн шинжилгээ” 1999он  
Д. Моломжамц “Санхүүгийн шинжилгээний онол арга зүйн асуудлууд” 2000он  
Ж. Бат-Өлзий “Бизнесийн байгууллагын санхүүгийн чадавхийг тодорхойлох асуудлууд” 2001он

Бүдүүвч 1

**Бизнесийн байгууллагын иж бүрэн шинжилгээний бүтэц**



Эх сурвалж: Б.Сайнжаргал

Судалгаанд хамааруулах үзүүлэлтүүдийн систем, арга зүйг сонгохдоо тухайн судалгааны зорилго, судалгааны мэдээлэл хэрэглэгчдийн ашиг сонирхол, байр сууринаас хандах нь чухал юм. Судалгааны зорилгод нийцсэн үзүүлэлтийг сонголтонд нэн тэргүүний баримтлах зарчмууд нь:

1. Судалгааны обектын санхүүгийн дүр зургийг бодитой, бүрэн илэрхийлж чадахуйц үзүүлэлтүүдийг сонгох;
2. Сонгосон үзүүлэлтүүд нь санхүүгийн тайлангийн болон бусад мэдээллийг ашиглан тооцоологдох боломжтой байх;
3. Мэдээлэл хэрэглэгчдэд ойлгомжтой, шийдвэр гаргахад нэн шаардлагатай үзүүлэлтүүдийг багтаасан байх;
4. Мэргэжлийн эрдэмтэд, судлаачдын санал дүгнэлт, дэвшилтэй үзэл баримтлал, арга зүйг харгалзсан байх учиртай гэж үзэж байна.

**Санхүүгийн шинжилгээний хөгжлийн чиг хандлага**

Манай улсын бизнесийн салбарын хөгжил, санхүүгийн мэдээллийн түгээлтийн өнөөгийн байдлаас дүгнэвэл санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийн цар хүрээг өргөтгөж, удирдлагын шийдвэр гаргалт, гүйцэтгэлийн үр дүнг дээшлүүлэхэд санхүүгийн шинжилгээний гүйцэтгэх үүргийг улам бүр нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Эдийн засгийн шинжилгээ улс орон, бүс нутаг, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны явц үр дүн, санхүү-эдийн засгийн үр ашиг, хөгжлийн түвшин, хэтийн төлөвийг тодорхой үзүүлэлтийн систем, тогтсон арга зүйгээр судалж, үнэлгээ дүгнэлт гаргадаг мэдлэгийн тухайлсан систем юм.

Эдийн засгийн шинжилгээний мэдээлэл боловсруулалтын болон эдийн засгийн ухаанд эзлэх байр суурь, онол арга зүйн үндэслэлийг боловсруулах, шинжилгээний агуулга зохион байгуулалтыг салбар шинжлэх ухааны үүднээс хөгжүүлэхэд ОХУ-ын эрдэмтэд /тэр дундаа Н.Р Вейцман, С.К. Татур, М.И. Баканов, А.Д. Шеремет болон бусад/-ийн оруулсан хувь нэмэр асар их бөгөөд тэд баланс судлал, эдийн засгийн шинжилгээний онолын үндэс, шинжилгээний системийн болон иж бүрэн хандлага, хүчин зүйлийн шинжилгээний чиглэлээр олон арван ном бүтээл туурвиж, мэргэжлийн боловсролын бие даасан судлагдахуун болгосныг тэмдэглэвэл зохино. ОХУ-д эдийн засгийн шинжилгээ үүсэн хөгжсөний түүх, үе шатыг судалсан нэг сэдэвт бүтээлүүд нэг бус хэвлэгдсэн<sup>2</sup>.

Манай улсын тухайд 1930-аад оны сүүл үеэс тусгай мэргэжлийн сургуулиудад шинжилгээний хичээл заагдах болж, 1957 онд “Үйлдвэрийн газрын аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ” хэмээх анхны ном хэвлэгдэн, 1960-аад оны сүүл 1970-аад оноос үйлдвэр аж ахуйн газруудын төлөвлөгөөний биелэлтэнд хэсэгчилсэн болон иж бүрэн шинжилгээ хийгдэх болсон нь тэр үеийн ЗХУ-ын сургалтын школ, чиглэлтэй салшгүй холбоотой бөгөөд одоо ч энэ байдал хадгалагдсаар байгааг бид буруу гэж үзэхгүй байгаа юм.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг хүлээн зөвшөөрч, нэвтрүүлж эхэлсэн 1990-ээд оны дунд үеэс Санхүүгийн тайлагналыг хэт хураангуйлан хялбарчилсанаас болж мэдээллийн багтаамж, хүрэлцэхүйц байдал алдагдан, санхүүгийн тайлангийн шинжилгээ нь зарим цөөн харьцааг тодорхойлохоор хязгаарлагдах болсоныг тэмдэглэвэл зохино.


Гэвч бүртгэлийн шинэчлэлтийн судалгаа, хэлэлцүүлгийн дүнд 2001 онд “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал” боловсруулагдан гарч, 2004 оноос Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгын журам батлагдан тайлангийн нэгтгэл албан ёсоор хийгдэх болсоноор санхүүгийн шинжилгээний агуулга, цар

<sup>2</sup> М.И Баканов, А.Д. Шеремет “Теория экономического анализа” 1998, 2000, 2005г  
С.Б. Баригольц, М.В Мельник “Методология экономического анализа деятельности хозяйствующего субъекта” 2003г

хүрээ нэмэгдэн, мэдээллийн бааз, тэдгээрийн харилцан уялдаа, хамаарал сайжирсаар байна (Бүдүүвч 2).

Бүдүүвч 2

**Удирдлагын шийдвэр гаргахад ашиглагдах санхүүгийн тайлангууд**




Эх сурвалж: Б.Сайнжаргал

Шинжилгээний эдийн засгийн, санхүүгийн, үйл ажиллагааны зэрэг чухам аль төрөл, чиглэл нь илүү давамгайлан хэрэглэгдэх нь гагцхүү бизнесийн удирдлагын тогтолцоо, мэдээлэл хэрэглэгчдийн тухайн үеийн эрэлт хэрэгцээнээс хамаардаг.

Зах зээлийн эдийн засаг хөгжсөн орнуудын хөгжлийн өнөөгийн хандлагаас үзвэл шинжилгээний санхүүгийн чиглэл давамгайлан хэрэглэгдэж байгаагийн тусгал, нөлөөгөөр манай улсад 1990-ээд оны дунд үеэс бизнесийн хүрээнд “Санхүүгийн тайлангийн шинжилгээ”, харин тайлангийн нэгтгэл болон салбарын түвшинд “Санхүү-эдийн засгийн шинжилгээ” хийгдэх боллоо. (Бүдүүвч 3)

Бүдүүвч 3

Санхүү-Эдийн засгийн шинжилгээний зохион байгуулалт



Эх сурвалж: Б.Сайнжаргал

Шинжилгээнд санхүү-эдийн засгийн чиг давамгайлах болсон нь нэг талаар Санхүүгийн бүртгэл, тайлагналын олон улсын стандартыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, улс орнууд үндэсний онцлогтойгоор нэвтрүүлэн хэрэглэх болсон, нөгөө талаар бизнес жинхэнэ утгаараа хөгжиж, санхүүгийн зах зээл өргөжин улам бүр даяарчлагдахын хэрээр санхүүгийн удирдлагын гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж байгаатай холбоотой гэж болох юм.

Тэгэхдээ санхүүгийн шинжилгээг зөвхөн санхүүгийн тайлангийн мэдээллийн хүрээгээр хязгаарлахгүйгээр бизнесийн байгууллагын санхүү төлбөрийн чадвар төдийгүй хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, хөрөнгө капиталын болон үнэт цаасны зах зээл, хөрөнгө оруулалтын үр ашиг, бизнесийн эрсдэл гээд санхүү эдийн засгийн утгаар нь авч үзэх шаардлага тавигдаж байна.